



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/513

Ховд

«Дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах тухай»

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Эх нутгийн уулс” ХХК-ийн хийж гүйцэтгэж буй Ховд аймгийн Мөст сумын Дотуур байрны их засварын ажлыг ашиглагчийн хүсэлтийн дагуу ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй нэмэлтээр хийгдсэн ажлыг нягтлан шалгаж нэмэлт гэрээ байгуулан санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой эсэх талаар шийдвэр гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Баярсүх

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Н.Ганзориг

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Д.Эрдэнэбат

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Д.Тогтохбаяр

- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

С.Баасандорж - Мөст сумын Засаг дарга

Д.Доржпүрэв - “Эх нутгийн уулс” ХХК-ийн захирал

Нарийн бичгийн

дарга: Б.Түмэндэмбэрэл

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. Тус ажлыг шийдвэрлэх боломжтой эсэх талаар ажлын хэсгийн дүгнэлтийг гаргаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

3. Дээрх ажилтай холбогдолтой гарах зардлыг захиалагчийн хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН